



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 08

Эрдэнэт

“Эмч” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 “е”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/02 дугаар тогтоолоор баталсан “Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Эмч хөтөлбөрийг нэгдүгээр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөвт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 2 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит
бус II хуралдааны 2021 оны 08 сарын 30-ны
едрийн 08 дугаар тогтоолын 1-р хавсралт



“ЭМЧ” ХӨТӨЛБӨР 2021-2024 он

Нэг. Хөтөлбөр хэрэгжүүлэх үндэслэл

Хөтөлбөрийг боловсруулахдаа Алсын хараа-2050, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, “Орхон аймаг, Эрдэнэт хотын ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2025”, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэс болголоо.

Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5-д “Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэн тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутагт дэвшилтэт технологи нэвтрүүлж нутагшуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг нэмэгдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах асуудлыг бодитойгоор шийдвэрлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авч буй үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлага, эмч, эмнэлгийн ажилтны хөгжлийн чиг хандлага, төр, захиргааны байгууллагын дэмжлэг зэргийг үндэслэн “Эмч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр боловсруулав.

Хоёр. Өнөөгийн нөхцөл байдал

“Эмч” хөтөлбөр нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 6/04 дүгээр тогтоолоор батлагдан 2017-2020 оны хугацаанд амжилттай хэрэгжсэн бөгөөд хэрэгжих хугацаанд эмч, эмнэлгийн мэргэжилтэнгүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр гадаадын 13 оронд 188 мэргэжилтнийг сургаж, туршлага судлуулж, дотоодын 199 сургалтад давхардсан тоогоор 9566 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсны үр дүнд 15 төрлийн шинэ технологи арга барилыг орон нутагт нутагшуулснаар иргэд чанартай тусламж үйлчилгээг орон нутагтаа авах нөхцөл боломж бүрдэж, лавлагаа шатлалын эмнэлгийн төвлөрлийг бууруулан, иргэдийн хүлээгдэл, чирэгдэл багассан байна. Тухайлбал Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Медипас эмнэлэг, Эмнэлэг сувиллын цогцолбороос Улаанбаатар хот руу 13А маягтаар лавлагаа шатлалын эмнэлэгт 2020 онд 1136 үйлчлүүлэгч илгээсэн нь 2019 онтой харьцуулахад 2 дахин багассан байна.

Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажиллагсдын эзлэх хувь суурь үзүүлэлтээс 22,7%-аар, мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн ажиллагсдын хувь 7,4%-аар өссөн байна.

Мөн нийт 2042 эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжин, эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулж, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангасан байна. Цаашид аймгийн хүн амын өсөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ, шаардлага, эмч, эмнэлгийн мэргэжилтний тогтвор суурьшил, тус хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эрүүл мэндийн ажилтнуудын санал, эрүүл мэндийн салбарт шинээр нэвтрүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ, хөрөнгө

оруулалт, технологийн бодлоготой уялдсан хүний нөөцийг бэлтгэх зэрэгт анхаарах зэргийг харгалзан “Эмч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээ үүсч байна. “Эмч” хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар хийгдсэн цахим судалгаанд нийт 438 эрүүл мэндийн ажилтан оролцсоноос 95,2% нь тус хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хүсэлтэй байгаагаар илэрхийлсэн байна.

Өнөөгийн байдлаар Орхон аймгийн хэмжээнд төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн 162 байгууллагад 1692 эрүүл мэндийн ажилтан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаагаас 20,9% /354/-ийг эмч, 24,8% /420/-ийг сувилагч, тусгай дунд мэргэжилтэн эзэлж байна. Хүний нөөцийн байршлаар авч үзвэл анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд нийт ажиллагсдын 10,1%, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 30%, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 9%, Эрдэнэт сувиллын цогцолборт 9%, эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн санд 17%, бусад байгууллагад 1,2% нь ажиллаж байна.

Орхон аймагт 2015 онд 10000 хүн амд ноогдох их эмчийн 27.4 байсан бол 2020 онд 33,9 болон нэмэгдэж аймгуудын дунджаас дээгүүр, улсын дундаж түвшинд байна. 10 000 хүн амд ноогдох сувилагч, тусгай дунд мэргэжилтний хангалт 40,2 байгаа нь аймгуудын дунджаас дээгүүр болон улсын дунджаас доогуур байгаа ба эмч сувилагчийн харьцаа 1:1.8 байна. Иймд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гол цөм болох сувилагчийн тоог нэмэгдүүлэх, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээтэй байна.

Аймгийн хэмжээнд нарийн мэргэжил эзэмшсэн эмч нараас Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 33.6%, хувийн хэвшлийн ортой эмнэлэгт 21.7 %, үүдэн эмнэлэгт 18.3 хувь, нарийн мэргэжилт эзэмшсэн сувилагч нараас нараас Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 46,2%, хувийн хэвшлийн ортой эмнэлэгт 21,4%, үүдэн эмнэлэгт 6,4 хувь ажиллаж байна. Мөн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн 22.1% нь мэргэжлийн зэрэг, 11.1% нь боловсролын зэрэгтэй байгаа ба жилд дунджаар 10-15 эмч мэргэжлийн болон боловсролын зэрэг ахиулж байна. Цаашид аймгийн хэмжээнд ялангуяа Бүсийн оношилгоо эмчилгээний төвд дотор, хавдар, ДОХ/БЗДХ, харшил, настан судлал, эмгэг судлалын чиглэлүүдээр эмч, хавдар, хөнгөвчлөх, нүүр ам судлал, мэс засал, харшил, сэтгэц, нярай, уламжлалт чиглэлүүдээр сувилагч бэлтгэх хэрэгцээ байна.

Эрүүл мэндийн ажилтнуудын насны бүтцийн хувьд дийлэнх буюу 46.0 хувийг 20-39 насны залуучууд эзэлж байгаа нь тэдний мэргэжлийн ур чадвар болон нийгмийн асуудалд анхаарах шаардлагатай байгааг харуулж байгаа ба ажилтан, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн 2020 оны байдлаар 19.1%-тай байна.

Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааны судалгаагаар нийт ажилчдын 14,2% нь өрх толгойлсон, 24.7% нь амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой байна. Нийт ажилтан, албан хаагчдын 51.2% нь хувийн орон сууцанд, 35.1% нь гэр хороололд хувийн хашаа байшин, гэрт, 4.6% нь түрээсийн сууцанд, 9.0% нь хамаатан садангийн хамт амьдардаг бөгөөд орон сууц худалдан авах зорилгоор 7.7% нь зээл авчээ. Эрүүл мэндийн ажилтнуудад орон сууцны хэрэгцээ их байгаа боловч хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хувь нь бага байна.

“Эмч” хөтөлбөрийн хүрээнд 1 удаа эрүүл мэндийн салбарын 1638 ажилтан, албан хаагчдыг 27 нэр төрлийн шинжилгээ, 10 нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт иж бүрнээр хамруулснаас 2 ажилтан эрүүл мэндийн хувьд түр хугацаагаар тэнцэхгүй, 10% нь эрүүл мэндийн эрсдэлтэй, 14,5% нэмэлт шинжилгээ хийлгэх шаардлагатай, 3,4% стационарт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарч эрүүл мэндийн байгууллагууд ажиллагсадаа эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.

Эрүүл мэндийн байгууллагын үйлчлүүлэгч-үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжид үндэслэн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, байгууллагын хөгжил, удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтыг сэтгэл ханамжийн судалгааг

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран эрүүл мэндийн 46 нэгжийн үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилчид нийт 1450 үйлчлүүлэгчээс судалгаа авч 2015 онд хийгдсэн хөндлөнгийн сэтгэл ханамжийн судалгааны дүнтэй харьцуулан дүгнэхэд Орхон аймгийн эрүүл мэндийн салбарт үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 12,9%-иар өссөн ч эмч, эмнэлгийн ажиллагсдын харьцаа хандлага, ёс зүйн төлөвшлийг сайжруулах шаардлага байгаа нь судалгааны дүгнэлтээс харагдаж байна. Иймд эмч, эмнэлгийн ажиллагсдын орчин үеийн эмчилгээ, оношилгоо болон сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмжийг ашиглахад цаг алдалгүй суралцах нөхцөл боломжоор хангах, шинэ технологи, арга барилыг орон нутагт нутагшуулж, иргэдэд орон нутагтаа оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэх, лавлагаа шатлалын эмнэлгүүдийн хүлээгдэл, төвлөрлийг бууруулах, эмч, ажиллагсдын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах зорилгоор “Эмч” хөтөлбөрийг цаашид үргэлжүүлэн хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Орхон аймгийн эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч нарын мэдлэг чадвар, ёс зүйн төлөвшлийг сайжруулах, гадаад харилцааг нээлттэй түвшинд хүргэх, шинэ технологи арга барилыг орон нутагт нутагшуулах, нийгмийн асуудлыг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтууд

4.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, төлөвшил, ёс зүй, хариуцлага, хандлагыг нэмэгдүүлэх

4.2. Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангаж, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх.

Тав. Хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд хийгдэх үндсэн үйл ажиллагаа

5.1. *Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, төлөвшил, ёс зүй, хариуцлага, хандлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:*

5.1.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах үндсэн, төрөлжсөн, мэргэшүүлэх сургалтад төлөвлөлтийн дагуу хамруулж, чадавхжуулах

5.1.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад хэлний түвшинг дээшлүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулах

5.1.3. Гадаадад мэргэжлийн чиглэлээр суралцах, гадаадын ижил мэргэжлийн эмч нартай холбоо тогтоох, туршлага солилцох зэрэг үйл ажиллагааг бодлогын түвшинд дэмжих

5.1.4. Мэргэжлийн болон боловсролын зэрэг ахиулах нөхцөл боломжийг бүрдүүлэх

5.1.5. Сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хийх боломжоор хангаж, дэмжих

5.1.6. Ажил мэргэжлийн туршлага солилцох, ажлын байр сэлгэн суралцах боломжийг бий болгох

5.1.7. Орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй хамтран ажиллах, туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх

5.1.8. Анагаахын төрөлжсөн номын сан байгуулах, up-to-date программ ашиглах боломжтой болгох

5.1.9. Жил бүр нарийн мэргэжлийн чиглэлээр эмч нарын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах

5.1.10. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, хэсгийн хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, алдаа, зөрчлийг бүртгэн мэдээлэх, эмнэлгийн ажилтны харилцаа хандлагыг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулах

5.1.11. Үйлчлүүлэгчид, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг авч, судалгаанд үндэслэн арга хэмжээг зохион байгуулах

5.1.12. Эрүүл мэндийн байгууллагуудын менежментийг сайжруулах, манлайллыг хөгжүүлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулах

5.2 Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангаж, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

5.2.1. Эрүүл мэндийн ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

5.2.2. Ажлын аюулгүй, ээлтэй, эрсдэлгүй, тав тухтай ажиллах нөхцөл орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

5.2.3. Орон сууцны дэмжлэг үзүүлэх, зээлийн болон түрээсийн орон сууцанд хамруулах

5.2.4. Нийгмийн ноцтой байдлын үед, ялангуяа ковидын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч, эмнэлгийн ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх

5.2.5. Ахмад эмч, сувилагч нарыг мэргэжлийн сургалтад хамруулж, цаг үеийн шинэ мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн хамтран ажиллах

5.2.6. Жил бүр “Тэргүүний эрүүл мэндийн ажилтан”-ыг сонгон шалгаруулж, урамшуулдаг байх

Зургаа. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим

- Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах
- Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх
- Эрүүл мэндийн ажилтны эрэлт хэрэгцээ, сонирхолд тулгуурласан, тэдний эрх ашигт нийцсэн байх, оролцоог хангасан байх

Долоо. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

7.1. “Эмч” хөтөлбөрийг 2021-2024 он хүртэл дунд хугацаанд хэрэгжүүлнэ.

Найм. Хөтөлбөрийн хамрах хүрээ

8.1. Хөтөлбөрт Орхон аймгийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нийт эрүүл мэндийн ажилтнууд хамрагдана.

Ес. Хөтөлбөрийн санхүүжилт, тайлагналт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд жил бүр төлөвлөгөө гарган, шаардагдах хөрөнгийг тухайн жилийн аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, улс болон орон нутгийн төсөвт тусгах замаар санхүүжүүлнэ.

Хөтөлбөрийн санхүүжилтийг хөтөлбөрт заасан бодлого, арга хэмжээний хүрээнд тухайн жилийн төсөвт тусгагдсан хөрөнгийн дүнд багтаан батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ тус бүрээр гаргаж, тайланг дараа

оны 1 дүгээр сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

Арав. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн:

- Эрүүл мэндийн мэдлэг, ур чадвартай хүний нөөц бүрдсэнээр хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлага, хандлага сайжирсан байна.
- Эрүүл мэндийн чиглэлээр гадаад харилцааг нээлттэй түвшинд хүргэсэн байна.
- Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгаа сайжирснаар тэдний сэтгэл ханамж дээшилж, тогтвор суурьшилтай ажиллана.

Хөтөлбөрийн үр дүн нь дараах үзүүлэлтээр хэмжигдэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2020 он/	2024 онд хүрэх түвшин	Мэдээллийн эх үүсвэр
<i>Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, төлөвшил, ёс зүй, хариуцлага, хандлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:</i>				
1	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	71.4	82	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
2	Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь /ахлах, тэргүүлэх/	22.1	26	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
3	Боловсролын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь /магистр, доктор/	11.1	13	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
4	Гадаадад мэргэжил дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	22.7	25	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
5	Гадаад хэлний түвшин дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	18.4	20	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
6	Судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	17	20	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
7	Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн, өгүүлэл нийтлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	18	20	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
8	Шинэ төрлийн эмчилгээ, үйлчилгээ нэвтрүүлсэн тоо	5	12	ЭМГ, Хүний нөөцийн тайлан

9	Ёс зүйн сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	1699	2000	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо
10	Иргэдээс ирсэн өргөдөлд гомдлын эзлэх хувь	3.1%	0	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо
<i>Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангаж, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд</i>				
11	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эмч, эмнэлгийн ажиллагсдын эзлэх хувь	85	90	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
12	Эмчлэн эрүүлжүүлсэн эрүүл мэндийн ажилтны тоо	42,8 /700/	43,7/740/	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
13	Шинээр тохижуулсан амрах өрөө болон чийрэгжүүлэлтийн өрөө	14	20	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
14	Гэр болон түрээсийн орон сууцанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	12	12	ЭМГ, Хүний нөөцийн тайлан
15	Нийгмийн ноцтой байдлын үед, ялангуяа ковидын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч, эмнэлгийн ажиллагсдын дэмжлэгт хамрагдсан хувь	-	40%	ЭМГ, Хүний нөөцийн тайлан

Арван нэг. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар хамтран хариуцаж, бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдуулна.


Хамтран хэрэгжүүлэх байгууллагууд:

- Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд
- Олон улсын байгууллагууд
- Төрийн бус байгууллагууд

Арван хоёр. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, үр дүнд шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн газрын баг хариуцан үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргана. Шаардлагатай бол мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийлгэнэ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит
бус II хуралдааны 2021 оны 06 сарын 30-ны
өдрийн 06 дугаар тогтоолын 2-р хавсралт



“ЭМЧ” ХӨТӨЛБӨРИЙН 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2021 он	2022 он	2023 он	2024 он	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Санхүүжилтийн эх үүсвэр
Зорилт 1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, төлөвшил, ёс зүй, хариуцлага, хандлагыг нэмэгдүүлэх										
1	Эмч, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон магистр, докторын сургалтад төлөвлөлтийн дагуу хамруулах	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	71,4%	73%	75%	78%	80%	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Улс болон орон нутгийн төсөв Тухайн байгууллагын төсөв
2	Орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэшүүлэх сургалтад хамрагдахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	70%	75%	80%	85%	90%	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Орон нутгийн төсөв
3	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд судалгаа шинжилгээний ажил хийх, өгүүлэл нийтлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Судалгааны шинжилгээний ажлын тоо, үр дүн	1	4	4	4	4	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд, Хандивлагч байгууллага	Орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөр Бусад эх үүсвэр
		Судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	17%	17,5%	18%	19%	20%			
4	Мэргэжлийн зэрэг ахиулахад дэмжлэг үзүүлэх	Мэргэжлийн зэрэгтэй эмчийн эзлэх хувь	22.1%	23%	24%	25%	26%	ЭМГ, ЭМБ-ууд	Эрүүл мэндийн байгууллагууд	
5	Өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх, магистр, докторт	Боловсролын зэрэгтэй эмчийн хувь		11.1%	12%	12.5%	13%	ЭМГ, Эрүүл мэндийн	ЗДТГ, Гадаад дотоодын их дээд сургууль,	Орон нутгийн төсөв

	суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх		11.1%						байгууллагууд	институт	
6	Гадаад улсад бэлтгэгдсэн эмч, мэргэжилтэн өөрийн мэдлэг, туршлагаа түгээн дэлгэрүүлэхийг дэмжих	Мэдлэг, туршлагаа дэлгэрүүлсэн эмч, мэргэжилтний тоо	-	2	2	2	2	2	ЭМГ ЗДТГ	Эрүүл мэндийн байгууллагууд	Орон нутгийн төсөв Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ
7	Эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад хэлний мэдлэгийн түвшинг үе шаттайгаар дээшлүүлэх, суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Гадаад хэлний мэдлэгийн түвшин, дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	18,4%	18,6%	19%	19,5%	20%	ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд		ЗДТГ	Орон нутгийн төсөв
8	Эмнэлгийн практикт шинэ төрлийн эмчилгээ, үйлчилгээг нэвтрүүлэх	Эмнэлгийн практикт нэвтэрсэн шинэ төрлийн эмчилгээ, үйлчилгээний тоо	5	3	3	3	3	3	Эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ	Бусад эх үүсвэр
9	Орчин үеийн техник технологи ашиглах, хэрэглэх аргад суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Суралцсан эрүүл мэндийн ажилтны тоо	3	10	10	10	10	10	ЭМГ	ЗДТГ, ЭМБ-ууд	Орон нутгийн төсөв
10	Эрүүл мэндийн байгууллагууд цахим тоног төхөөрөмж ашиглан санал солилцох боломжийг бүрдүүлж, нэвтрүүлэх	Цахим тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо	2	1	1	1	1	1	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Бусад эх үүсвэр
11	Гадаад, дотоодын эмч нартай ажил мэргэжлийн туршлага солилцох, ажлын байр сэлгэн ажиллах нөхцөлийг бий болгох	Сэлгэн ажилласан эмчийн тоо	-	3	3	3	3	3	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд, Хандивлагч орнууд	Орон нутгийн төсөв
12	Анагаах ухааны төрөлжсөн номын сан байгуулах	Номын сангийн тоо	2			1			ЭМГ	Медипас эмнэлэг, Эрүүл мэндийн	Бусад эх үүсвэр

									байгууллагууд	
13	Нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулах	Уулзалт, зөвлөгөөний тоо, үр дүн	1	1	1	1	1	ЭМГ	Эрүүл мэндийн байгууллагууд, ЗДТГ	Орон нутгийн төсөв
14	Эрүүл мэндийн ажилтны ёс зүйг хувь хүний хандлагад тулгуурлан төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах	Ёс зүйн зөрчил гараагүй байх	-	-	-	-	-	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо	ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ Орон нутгийн төсөв Бусад эх үүсвэр
15	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, байгууллагын хөгжил, удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор үйлчлүүлэгчид, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг авах, судалгааны дүнд үндэслэн арга хэмжээг зохион байгуулах	Сэтгэл ханамжийн судалгаа хийсэн тоо, үр дүн	80%	-	85%-иас дээш	-	85%-иас дээш	"Залуу эмч нарын холбоо" ТББ	ЗДТГ, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	Орон нутгийн төсөв
16	Эрүүл мэндийн байгууллагуудын менежментийг сайжруулах, манлайллыг хөгжүүлэх чиглэлээр сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Сургалтад хамрагдсан байгууллагын тоо	2	4	4	4	4	ЭМГ	Төрийн албаны салбар зөвлөл, Удирдлагын академи Төрийн бус байгууллага	Улс болон орон нутгийн төсөв
Зорилт 2. Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ.										
17	Эрүүл мэндийн ажилтнуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилтны хувь, эмчлэн эрүүлжүүлсэн ажлын үр дүн	85%	80%-иас дээш	80%-иас дээш	80%-иас дээш	80%-иас дээш	Эрүүл мэндийн байгууллага уд	Аймгийн эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэл, ЭМГ	Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ Эрүүл мэндийн даатгалын сан

18	Эрүүл мэндийн салбарын ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх чийрэгжүүлэлт болон амрах өрөөг засаж, тохижуулах	Тохижуулсан танхимын тоо	5	1	1	1	1	Эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ, ЗДТГ, Хандивлагч байгууллага	Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ
19	Гэр болон түрээсийн орон сууцанд хамруулах	Хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	12	3	3	3	3	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Олон улсын төсөл хөтөлбөр
20	Ахмад эмч, сувилагч нарыг мэргэжлийн сургалтад хамруулж цаг үеийн мэдээллээр ханган хамтран эрүүл мэндийн арга хэмжээ зохион байгуулах	Сургалт мэдээлэлд хамрагдсан хувь	-	10%	15%	20%	25%	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Орон нутгийн төсөв Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ
21	Нийгмийн ноцтой байдлын үед, ялангуяа ковидын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч, эмнэлгийн ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх	Нийгмийн ноцтой байдлын үед, ялангуяа ковидын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч, эмнэлгийн ажиллагсдын дэмжлэгт хамрагдсан хувь	-	25%	30%	35%	40%	ЭМГ	Аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд Орон нутгийн төсөв	Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ
22	Жил бүр аймгийн "Тэргүүний эрүүл мэндийн ажилтан"-ийг сонгон шалгаруулж, урамшуулдаг байх	Шалгарсан эрүүл мэндийн ажилтны тоо	-	1	1	1	1	ЭМГ	Эрүүл мэндийн байгууллагууд, ЗДТГ	Орон нутгийн төсөв